



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/67

Улаанбаатар хот

Т.Энх-Амгаланг сургалтад хамруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.7, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүгд найрамдах Солонгос улсад зохион байгуулагдах Хот нийтийн аж ахуй, Хог хаягдал, Тохижилт, Ногоон байгууламжийн чиглэлийн сургалтад тус албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Түмэндэмбэрэлийн Энх-Амгаланг 2019 оны 04 дүгээр сарын 09-нөөс 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийг дуустал хугацаанд хамруулсугай.

2. Т.Энх-Амгаланд дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.33 дахь заалтын дагуу сургалтад хамрагдсан хугацааны цалинг олгохыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

3. Сургалтын тайланг ирснээс хойш ажлын 5 хоногийн дотор Захиргаа, санхүүгийн хэлтэст ирүүлэхийг мэргэжилтэн Т.Энх-Амгаланд даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

